**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2025/011/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:261663 Цахим хаяг: naramchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цогбаяр<br>Утас: 261885 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Ариунжаргал<br>Утас: 261885 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn<br>Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг<br>Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/829

танай ____________-ны №____________-т

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН СУРГАЛТ, ҮНЭЛЭЭ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТЫН ЗАХИРАЛ М.БАТГЭРЭЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1,8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг хэмжээний дараах зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

1. Барилгын их засварт 178,410.1 мянган төгрөг зарцуулсныг барилгын өртгийг капиталжуулж бүртгээгүй, тусад нь бүртгэсэн.
2. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 137,238.1 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглаагүй байхад хөрөнгийн ашиглах хугацааг бодитой тооцоогүйгээс элэгдлийн зардлыг буруу тооцож үлдэгдэл өртөггүй тайлагнасан, мөн Сонгинохайрхан дүүрэгт байрлалтай 3 давхар конторын барилгын зөвхөн 3 дугаар давхарыг үйл ажиллагаанд ашиглаж, 1 болон 2 дугаар давхар нь ашиглалтгүй байна.
3. Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн нийт 26,532.8 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглаагүй байхад элэгдлийн зардал тооцсон;
4. Тайлант оны 147,964.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бүртгээгүй;
5. Тайлант онд худалдан авсан чадамжийн гэрчилгээний зарцуулалтын анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, харилцагчтай хийх тооцоог бүрэн хийгээгүй, авлагыг аккруэл сууриар бүртгээгүй зэрэг зөрчлүүдээс 8,540.0 мянган төгрөгийн

орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлээгүй, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн ба зохистой байх", "Үнэн ба зөв байх", "үнэлгээ ба хувиарлалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,831,355.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 1,530,962.9 мянган төгрөг, томилолтын зардалд 38,87.5 мянган төгрөг зарцуулж 261,555.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сүүлийн 2 жилд хийгдсэн судалгаа, шинжилгээний зардалд 2,103,028.2 мянган төгрөгийг зарцуулахдаа төсөвт ажлын 70.0 гаруй хувийн ажлыг гадны байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэн ажилладаг, судалгаа шинжилгээний ажлуудын захиалга, хэрэгцээ шаардлага нь тодорхой бус, хэрэглэсэн үр дүн багатай, үр ашиггүй байна.

**Бусад асуудал**

Ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн болон мэргэшлийн түвшнээ ахиулах иргэнийг ажил олгогчийн захиалгаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй мэргэжлээр ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлэлт, тогтвортой ажлын байрыг дэмжихэд чиглэсэн сургалтууд хийдэг боловч ажлын байраар хангагдсан эсэхийг хянадаггүй, үр дүн багатай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АТА9693 9006109
9023030583

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **168,933,977.40** | **363,680,086.50** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **-** | - |
| **31200** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **-** | **-** |
| **31210** | **Төгрөг** | **-** | **-** |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | - | **-** |
| **33** | **АВЛАГА** | **72,533,805.68** | **252,221,666.78** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 38,586.54 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 72,533,805.68 | 252,183,080.24 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **96,400,171.72** | **111,458,419.72** |
| **35400** | **Хангамжийн материал** | **96,400,171.72** | **111,458,419.72** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,240,070.00 | 16,357,990.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 113,000.00 | 58,498.00 |
| 35430 | Сэлбэг | - | 310,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 90,047,101.72 | 94,731,931.72 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,439,176,041.50** | **1,584,074,176.23** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,439,176,041.50** | **1,584,074,176.23** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **1,436,967,581.75** | **1,562,524,242.89** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,413,098,075.21 | 1,413,098,075.21 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (278,194,175.98) | ( 316,613,316.94) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 95,200,000.00 | 58,733,333.33 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (95,200,000.00) | ( 43,538,888.88) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 663,185,009.93 | 675,650,604.04 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (489,697,670.20) | ( 419,813,097.47) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 356,397,824.68 | 302,511,356.18 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (233,372,481.89) | ( 113,054,822.58) |
| 39217 | Ном | 5,551,000.00 | 5,551,000.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **2,208,459.75** | **21,549,933.34** |
| 39301 | Программ хангамж | 16,573,201.79 | 13,950,701.79 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (14,364,742.04) | ( 8,912,768.45) |
| **39303** | Бусад биет бус хөрөнгө | - | 16,512,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,608,110,018.90** | **1,947,754,262.73** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,428,459.29** | **2,762,983.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **3,428,459.29** | **2,762,983.00** |
| **41300** | **Өглөг** | **3,428,459.29** | 2,762,983.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 2,758,459.29 | 2,762,983.00 |
| 41313 | ХАОАТ-ын өглөг | - | 2,762,983.00 |
| **41360** | **Бусад өглөг** | **670,000.00** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 670,000.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,604,681,559.61** | **1,944,991,279.73** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,604,681,559.61** | **1,944,991,279.73** |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,604,681,559.61** | **1,944,991,279.73** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,872,210,487.80 | 1,607,440,018.90 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (267,528,928.19) | 337,551,260.83 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,608,110,018.90** | **1,947,754,262.73** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,005,956,926.05** | **4,096,978,419.54** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **206,106,303.00** | **447,241,057.54** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **206,106,303.00** | **447,241,057.54** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **206,106,303.00** | **147,964,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 206,106,303.00 | 147,964,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | - | 299,277,057.54 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,799,850,623.0** | **3,649,737,362.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,395,966,100.00** | **1,890,915,300.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,395,966,100.00 | 1,890,915,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **403,884,523.05** | **1,758,822,062.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 1,758,822,062.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 403,884,523.05 | - |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,265,867,669.12** | **3,757,541,982.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,265,867,669.12** | **3,757,541,982.24** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,245,897,358.84** | 3,730,707,338.41 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,499,010,255.91** | 1,628,821,639.39 |
| 210101 | Үндсэн цалин | 798,876,178.51 | 1,049,386,671.61 |
| 210102 | Нэмэгдэл | 246,753,100.91 | 235,176,303.59 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 174,929,150.25 | 202,880,360.82 |
| 210104 | Урамшуулал | 35,951,933.74 | 141,378,303.37 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 242,499,892.50 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **147,326,980.10** | **206,594,516.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 88,545,823.74 | 133,584,263.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,088,300.00 | 18,252,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,997,200.00 | 9,126,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,996,200.00 | 9,126,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 28,699,456.36 | 36,505,053.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **18,595,798.46** | **18,980,849.62** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,591,591.06 | 6,441,966.46 |
| 210302 | Түлш, халаалт | 10,092,207.68 | 10,932,524.28 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,911,999.72 | 1,606,358.88 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **115,174,594.00** | **84,135,771.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 72,757,300.00 | 63,246,779.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,221,900.00 | 110,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 22,597,306.00 | 16,807,532.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,152,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 77,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,369,088.00 | 3,971,460.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **65,350,080.00** | **9,050,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 35,750,080.00 | 190,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 29,600,000.00 | 8,860,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **37,949,939.00** | **49,169,710.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 37,895,000.00 | 48,389,710.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 54,939.00 | 780,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,396,058.00** | **8,643,152.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 264,300.00 | 1,272,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 114,100.00 | 89,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 167,252.00 | 69,752.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 53,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,712,900.00 | 1,751,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 84,506.00 | 93,900.00 |
| **210809** | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | 344,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **353,093,653.37** | **1,725,311,700.40** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,434,282.81 | 25,109,757.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 134,084,245.51 | 1,524,793,797.06 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 192,575,125.05 | 175,408,146.34 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19,970,310.28** | **26,834,643.83** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **15,124,263.00** | **11,092,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,124,263.00 | 11,092,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **4,846,047.28** | **15,742,643.83** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,751,115.28 | 6,370,343.15 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 94,932.00 | 9,372,300.68 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(259,910,743.07 )** | **339,436,437.30** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **7,618,185.12** | **1,885,176.48** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 7,618,185.12 | 1,885,176.48 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(267,528,928.19 )** | **337,551,260.83** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,154,530,003.0** | **3,870,235,167.68** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **206,106,303.00** | **147,964,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **206,106,303.00** | 147,964,000.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **206,106,303.00** | 147,964,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 206,106,303.00 | 147,964,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,948,423,700.00** | **3,722,271,167.68** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,395,966,100.00** | **1,890,915,300.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,395,966,100.00 | 1,890,915,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **552,457,600.00** | **1,831,355,867.68** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 147,396,074.00 | 1,831,355,867.68 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 405,061,526.00 | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,133,299,103.00** | **3,847,320,767.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,133,299,103.00** | **3,847,320,767.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,040,794,987.04** | **3,568,303,043.61** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,497,319,594.16** | **1,626,097,242.93** |
| 210101 | Үндсэн цалин | 798,543,240.26 | 1,046,662,275.15 |
| 210102 | Нэмэгдэл | 246,753,100.91 | 235,176,303.59 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 174,929,150.25 | 202,880,360.82 |
| 210104 | Урамшуулал | 35,951,933.74 | 141,378,303.37 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 241,142,169.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **147,326,980.10** | **206,594,516.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 88,545,823.74 | 133,584,263.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 15,088,300.00 | 18,252,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,997,200.00 | 9,126,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,996,200.00 | 9,126,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 28,699,456.36 | 36,505,053.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **18,595,798.46** | **18,980,849.62** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,591,591.06 | 6,441,966.46 |
| 210302 | Түлш, халаалт | 10,092,207.68 | 10,932,524.28 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,911,999.72 | 1,606,358.88 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **95,293,243.00** | **97,679,551.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 42,803,950.00 | 59,986,249.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,221,900.00 | 453,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 22,597,306.00 | 16,807,532.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,152,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 77,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,441,087.00 | 20,431,870.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **68,243,080.00** | **15,082,065.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 38,643,080.00 | 4,562,065.00 |
| 210604 | Урсгал засвар | 29,600,000.00 | 10,520,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **38,466,070.00** | **49,169,710.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 37,895,000.00 | 48,389,710.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 571,070.00 | 780,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **18,543,808.00** | **13,843,152.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 264,300.00 | 1,272,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,000,000.00 | 5,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 114,100.00 | 89,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 167,252.00 | 69,752.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношил гоо | 53,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 6,712,900.00 | 1,751,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 84,506.00 | 93,900.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 9,147,750.00 | 5,544,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **157,006,413.32** | **1,540,855,957.06** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,922,167.81 | 4,413,990.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 134,084,245.51 | 1,536,441,967.06 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **92,504,115.96** | **279,017,724.07** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **15,124,263.00** | **11,092,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,124,263.00 | 11,092,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **77,379,852.96** | **267,925,724.07** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,751,115.28 | 6,370,343.15 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 72,628,737.68 | 261,555,380.92 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **21,230,900.00** | **22,914,400.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **21,231,200.00** | **22,914,400.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **21,231,200.00** | **22,914,400.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **21,231,200.00** | **22,914,400.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 21,231,200.00 | 22,914,400.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(21,231,200.00 )** | **-** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **(300.00 )** | **-** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 300.00 | - |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **1,872,210,487.80** | **1,872,210,487.80** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | **-** | **-** | **-** | **-** |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | 1,872,210,487.80 | 1,872,210,487.80 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | **( 267,528,928.18)** | **( 267,528,928.18)** |
| **11** | **2023 оны 12-р сарын31-нээрх үлдэгдэл** | - | - | **1,604,681,559.62** | **1,604,681,559.62** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 2,758,459.29 | 2,758,459.29 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **-** | **1,607,440,018.90** | **1,607,440,018.90** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| 18 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 337,551,260.83 | 337,551,260.83 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **-** | **1,944,991,279.73** | **1,944,991,279.73** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих** | **2,287,879,800.00** | **2,032,508,956.85** | **255,370,843.15** | **88.84** |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,287,879,800** | **2,032,508,956.85** | **255,370,843.15** | **88.84** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,287,879,800** | **2,032,508,956.85** | **255,370,843.15** | **88.84** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,276,683,100** | **2,021,416,956.85** | **255,266,143.15** | **88.79** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,762,246,100** | **1,626,097,242.93** | **136,148,857.07** | **92.27** |
| Үндсэн цалин | 1,171,344,200 | 1,046,662,275.15 | 124,681,924.85 | 89.36 |
| Нэмэгдэл | 363,645,200 | 235,176,303.59 | 128,468,896.41 | 64.67 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 103,821,300 | 202,880,360.82 | (99,059,060.82) | 195.41 |
| Урамшуулал | 123,435,400 | 141,378,303.37 | (17,942,903.37) | 114.54 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **228,157,100** | **206,594,516.00** | **21,562,584.00** | **90.55** |
| Тэтгэврийн даатгал | 155,146,800 | 133,584,263.00 | 21,562,537.00 | 86.10 |
| Тэтгэмжийн даатгал | 18,252,700 | 18,252,700.00 | - | 100.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 9,126,200 | 9,126,200.00 | - | 100.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 9,126,300 | 9,126,300.00 | - | 100.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 36,505,100 | 36,505,053.00 | 47.00 | 100.00 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **21,130,500** | **18,980,849.62** | **2,149,650.38** | **89.83** |
| Гэрэл, цахилгаан | 7,088,200 | 6,441,966.46 | 646,233.54 | **90.88** |
| Түлш, халаалт | 10,758,000 | 10,932,524.28 | (174,524.28) | 101.62 |
| Цэвэр, бохир ус | 3,284,300 | 1,606,358.88 | 1,677,941.12 | **48.91** |
| **Хангамж, бараа материалын зардал** | **97,031,800** | **89,770,991.00** | **7,260,809.00** | **92.52** |
| Бичиг хэрэг | 61,179,900 | 60,486,049.00 | 693,851.00 | 98.87 |
| Тээвэр, шатахуун | 2,066,700 | 453,900.00 | 1,612,800.00 | 21.96 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 17,713,500 | 16,807,532.00 | 905,968.00 | 94.89 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,160,100 | - | 1,160,100.00 | - |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 14,911,600 | 12,023,510.00 | 2,888,090.00 | 80.63 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **51,475,000** | **45,905,025.00** | **5,569,975.00** | **89.18** |
| Багаж, техник, хэрэгсэл | 27,665,000 | 26,976,665.00 | 688,335.00 | 97.51 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 9,000,000 | 8,408,360.00 | 591,640.00 | 93.43 |
| Урсгал засвар | 14,810,000 | 10,520,000.00 | 4,290,000.00 | 71.03 |
| **Томилолт, зочны зардал** | **20,362,700** | **10,332,200.00** | **10,030,500.00** | **50.74** |
| Дотоод албан томилолт | 19,575,800 | 9,552,200.00 | 10,023,600.00 | **48.80** |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | 786,900 | 780,000.00 | 6,900.00 | 99.12 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **81,905,000** | **13,843,152.00** | **68,061,848.00** | **16.90** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 68,174,000 | 1,272,900.00 | 66,901,100.00 | 1.87 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 5,002,700 | 5,000,000.00 | 2,700.00 | 99.95 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Даатгалын үйлчилгээ | 530,100 | 89,100.00 | 441,000.00 | 16.81 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 375,000 | 69,752.00 | 305,248.00 | 18.60 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 52,100 | 22,000.00 | 30,100.00 | **42.23** |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,928,400 | 1,751,500.00 | 176,900.00 | **90.83** |
| Газрын төлбөр | 93,900 | 93,900.00 | - | **100.00** |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 5,748,800 | 5,544,000.00 | 204,800.00 | **96.44** |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **14,374,900** | **9,892,980.30** | 4,481,919.70 | **68.82** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 4,488,900 | 4,413,990.00 | 74,910.00 | **98.33** |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,886,000 | 5,478,990.30 | 4,407,009.70 | **55.42** |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **11,196,700** | **11,092,000.00** | **104,700.00** | **99.06** |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 11,196,700 | 11,092,000.00 | 104,700.00 | **99.06** |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,287,879,800** | **2,032,508,956.85** | **255,370,843.15** | **88.84** |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,890,915,300** | **1,884,544,956.85** | **6,370,343.15** | **99.66** |
| Улсын төсвөөс санхүүжих | 1,890,915,300 | 1,884,544,956.85 | 6,370,343.15 | 99.66 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **396,964,500.00** | **147,964,000.00** | **249,000,500.00** | **-** |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 396,964,500.00 | 147,964,000.00 | 249,000,500.00 | **-** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | **-** | - | - | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **75** | **59** | **16** | **78.7** |
| Удирдах ажилтан | 4 | 4 | 4 | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 67 | 51 | 16 | 76.1 |
| Үйлчлэх ажилтан | 4 | 4 | 4 | 100.0 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **1,831,355,867.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **1,831,355,867.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **-** | **1,569,800,486.76** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **-** | **-** |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **-** | **-** |
| 210401 | Бичиг хэрэг | - | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | - |
| 210404 | Ном, хэвлэл | - | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **-** | **-** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **38,837,510.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 38,837,510.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **-** | **1,530,962,976.76** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | - |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 1,530,962,976.76 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **261,555,380.92** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **261,555,380.92** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 261,555,380.92 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** | **1,831,355,867.68** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 1,831,355,867.68 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 1,831,355,867.68 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | - |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **-** | **-** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 3,467.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 626.5 сая төгрөгийн алдааг залруулж, 10.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 311.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 2,155.8 сая төгрөгийн хариуцлага тооцох албан шаардлагыг тус тус хүргүүлж, 362.9 сая төгрөгийн зөвлөмж өгч,

3.1. Аудитаар нийт 626.5 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэлгээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 78 нэр төрлийн 410,273.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дансанд бүртгэхдээ хөрөнгийн нэршлийг алдаатай бүртгэсэн байна. | 1 | 410,273.4 | - | - | 1 | 410,273.4 | 1 | 410,273.4 | - | - |
| Цахим татварын системийн татварын тодорхойлолтод 17,751.4 мянган төгрөгийн татварын өрийн үлдэгдэлтэй байгаа боловч санхүүгийн тайланд татварын өрийн үлдэгдэлгүйгээр тайлагнасан байна. | 1 | 17,751.4 | 1 | 17,751.4 | - | - | 1 | 17,751.4 | - | - |
| Цалингийн тооцооны хүснэгтэд тусгагдсан цалингийн дүн Нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан дүнгээс 55,642.7 мянган төгрөгийн зөрүүтэй | 1 | 55,642.7 | 1 | 55,642.7 | - | - | 1 | 55,642.7 | - | - |
| Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалын байгууллагад 62,744.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. | 1 | 62,744.7 | 1 | 62,744.7 | - | - | 1 | 62,744.7 | - | - |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2024.12.31-ний байдлаар ирүүлсэн Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулгын нэмэгдсэн хөрөнгийн дүн 456,426.6 мянган төгрөг байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээр нэмэгдсэн хөрөнгийн дүн 472,938.6 мянган төгрөг буюу 16,512.0 мянган төгрөгөөр зөрүүтэй. | 1 | 16,512.0 | 1 | 16,512.0 | - | - | 1 | 16,512.0 | - | - |
| Аудитын ирүүлсэн цалингийн хүснэгтээр ажилчдын цалин хөлсийг үнэн зөв тооцсон эсэхийг давтан тооцоолол хийхэд 1-р сард 4 ажилтны олговол зохих цалинг 2,059.8 мянган төгрөгөөр илүү, 4-р сард 51 ажилтны олговол зохих цалинг 22,574.2 мянган төгрөгөөр илүү, 1 ажилтны олговол зохих цалинг 148.4 мянган төгрөгөөр дутуу, 6-р сард 2 ажилтны олговол зохих цалинг 893.0 мянган төгрөгөөр илүү, 7-р сард 54 ажилтны олговол зохих цалинг 34,550.0 мянган төгрөгөөр илүү, 9-р сард 1 ажилтны олговол зохих цалинг 648.4 мянган төгрөгөөр дутуу тооцсон байна. | 1 | 60,873.8 | 1 | 60,873.8 | - | - | 1 | 60,873.8 | - | - |
| Нийгмийн даатгалын байгууллагад тайлагнасан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дүн нь 1,705,275.5 мянган төгрөг байгаа бөгөөд татварын байгууллагад илгээсэн Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан/ТТ-11/-д 1,702,550.5 мянган төгрөгөөр тайлагнаж, 2,725.0 мянган төгрөгийн зөрүүтэй | 1 | 2,725.0 | 1 | 2,725.0 | - | - | 1 | 2,725.0 | - | - |
| **Дүн** | **7** | **626,523.0** | **6** | **216,249.6** | **1** | **410,273.4** | **7** | **626,523.0** | **-** | **-** |

3.2 Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 689.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 10.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 311.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 3.8 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, хариуцлага тооцох албан шаардлагыг тус тус хүргүүлж, 362.9 сая төгрөгийн зөрчлийг давтан, гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="3">Зөрчлийн товч утга</th><th colspan="2" rowspan="2">Нийт зөрчил</th><th colspan="8">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Төлбөрийн акт</th><th colspan="2">Албан шаардлага</th><th colspan="2">Зөвлөмж</th><th colspan="2">Хариуцлага тооцуулах албан шаардлага</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th></tr>
<tr><td>Өмнөх аудитаар тайлант жилийн элэгдлийн зардлыг 19,631.7 мянган төгрөгөөр дутуу, 3 нэр төрлийн хөрөнгөнд элэгдэл байгуулаагүй, ашиглалтын хугацаа дууссан 3 нэр төрлийн хөрөнгөд 2,584.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг илүү тооцсон, 140,480.0 мянган төгрөгийн 4 нэр төрлийн хөрөнгийн ашиглалтын хугацааг бодиттой тооцоогүй, ижил төрлийн хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг зөрүүтэй бүртгэсэн, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой 92 нэр төрлийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй зэрэг алдааг залруулахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.</td><td>1</td><td>22,216.6</td><td>-</td><td>-</td><td>1</td><td>22,216.6</td><td>-</td><td>-</td><td>-</td><td>-</td></tr>
</table>

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өмнөх оны аудитаар “Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны А-1/2464 тоот албан бичгийн хавсралт дах 4,832.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасах байтал тус хөрөнгүүд нь бусад хангамжийн материалд бүртгэлтэй байсан, өмнөх жилүүдэд данснаас хасагдсан хөрөнгүүдийг давхар тоологдож дансанд бодитоор оршин байхгүй зэрэг зөрчилтэй байна.” гэсэн зөрчил албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжүүлээгүй байна. | 1 | 3,795.0 | - | - | - | - | - | - | 1 | 3,795.0 |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд цалин хөлс, нэмэгдэл урамшууллын дунд хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 3,680.3 мянган төгрөгийн зардлыг оруулсан | 1 | 3,680.3 | - | - | - | - | 1 | 3,680.3 | - | - |
| Барилгын их засварын ажилд зарцуулсан 178,410.1 мянган төгрөгийг хөрөнгийг капиталжуулан бүртгээгүй, их засвар гэсэн нэршлээр тусад нь биет хөрөнгөөр бүртгэсэн байна. | 1 | 178,410.1 | - | - | - | - | 1 | 178,410.1 | - | - |
| Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 137,238.1 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглаагүй байхад хөрөнгийн ашиглах хугацааг бодитой тооцоогүйгээс элэгдлийн зардлыг буруу тооцож үлдэгдэл өртөггүй тайлагнасан, мөн Сонгинохайрхан дүүрэгт байрлалтай 3 давхар конторын барилгын зөвхөн 3 дугаар давхрыг үйл ажиллагаанд ашиглаж, 1 болон 2 дугаар давхар нь ашиглалтгүй байна, тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн нийт 26,532.8 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглаагүй байхад элэгдлийн зардал тооцсон; | 1 | 163,771.0 | - | - | - | - | 1 | 163,771.0 | - | - |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тайлант онд 396,964.5 мянган төгрөгийн төсөвт байгууллагын өөрийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 147,964.0 мянган төгрөгийн орлого олж 37.3 хувийн биелэлттэй буюу орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, батлагдсан төсвийг хэрэгжүүлэн ажиллаагүй, тодотгол хийлгээгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| Тайлант оны 147,964.0 мянган төгрөгийн өөрийн орлогыг нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бүртгээгүй | 1 | 147,964.0 | - | - | 1 | 147,964.0 | - | - | - | - |
| Тайлант онд худалдан авсан чадамжийн гэрчилгээний зарцуулалтын анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, худалдан авагчтай тооцоог хийгээгүй, авлагыг бүртгээгүй, 8,540.0 мянган төгрөгийн орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлээгүй байна. | 1 | 8,540.0 | 1 | 8,540.0 | - | - | - | - | - | - |
| 2024 оны 7-р сард олгосон 24 ажилтны ээлжийн амралтын 17,079.1 мянган төгрөгийг олговол зохих цалинд оруулаагүй орхигдуулж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан болон Хувь орлогын албан татварын тайланд тусгаагүй байна. | 1 | 17,079.1 | - | - | - | - | 1 | 17,079.1 | - | - |
| Цалингийн урьдчилгаанд олгосон 24,352.9 мянган төгрөгийг сарын сүүлийн цалингаас суутгаагүй олгосныг нөхөж суутгахдаа нэг ажилтнаас 267.4 мянган төгрөгийг суутгаагүй байна. | 1 | 267.4 | 1 | 267.4 | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Илүү цагийн цалинг 4 хүнд 657.1 мянган төгрөг илүү олгосон. | 1 | 657.1 | 1 | 657.1 | - | - | - | - | - | - |
| Ажилчдын ур чадвартай эсэхийг нотлох шалгуур үзүүлэлтээр ажлын гүйцэтгэлийг үнэлсэн нотлох баримтгүй сар бүр тогтмол хэмжээгээр нийт ажиллагсдын 85.0 хувьд 141,715.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна. 6-12 сарын хооронд 18 ажилтанд хангалттай үнэлгээ хийлгүйгээр зөвхөн ур чадварын нэмэгдэл авах өргөдөл гаргасныг үндэслэл болгож 10-25 хувиар нэмэгдлийг олгож эхэлсэн байна. | 1 | 141,715.7 | - | - | 1 | 141,715.7 | - | - | - | - |
| Албан томилолтоор ажилласан 14 ажилтанд нийт 1,120.0 мянган төгрөгийн хоол, унааны мөнгө давхардуулан олгосон байна. | 1 | 1,120.0 | 1 | 1,120.0 | - | - | - | - | - | - |
| Сүүлийн 2 жилд хийгдсэн судалгаа, шинжилгээний зардалд 2,103,028.2 мянган төгрөгийг зарцуулахдаа төсөвт ажлын 70.0 гаруй хувийн ажлыг гадны байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэн ажилладаг, судалгаа шинжилгээний ажлуудын захиалга, хэрэгцээ шаардлага нь тодорхой бус, хэрэглэсэн үр дүн багатай, үр ашиггүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| "Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөрөөр 20 мэргэжлээр 1167 иргэнийг 1,493,224.9 мянган төгрөгөөр сургасан байна. Хөтөлбөрийн Санал зөвлөмж хэсэгт "Эрэлтэд нийцсэн ур чадвар хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ зорилтод иргэдээс санал авч эрэлттэй мэргэжлийг тодорхойлох" гэж тусгасан байна. Тус байгууллага сургалтын үр дүнг тооцож үнэлдэггүй ажлын байраар хангагдсан иргэдийн судалгааг гаргаагүй. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| **Дүн** | **15** | **689,216.3** | **4** | **10,584.5** | **3** | **311,896.3** | **7** | **362,940.5** | **1** | **3,795.0** |

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудиттай холбоотой нийт 2,151.9 сая төгрөгийн зөрчил илэрснийг хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Хариуцлага тооцох албан шаардлага | |
|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | |
| Өмнөх оны аудитаар "Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулж байх" гэсэн зөвлөмж хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд оруулбал зохих 171 мэдээллээс 167 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 29 удаагийн 1,918,955.9 мянган төгрөгийн орлого, 17 удаагийн 233,016.0 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд хугацаа хоцроож байршуулсан байна." гэсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжээгүй байна. | 1 | 2,151,971.9 | 1 | 2,151,971.9 |
| **Нийт дүн** | **1** | **2,151,971.9** | **1** | **2,151,971.9** |